


ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТҮҮХ УГСААГНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
МОНГОЛЫН УГСААТАН СУДЛААЧДЫНХОЛБОО

МОНГОЛЫН УГСААТАН СУДЛАЛ-2020

ОРДМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

МОНГОЛЫН УГСААТАН СУДЛАЛ-2020



"Соямбо принтинг" хэвлэлийн үйлдвэр, хэвлэл
11 325052, 9956 9646, 9556 9646, 9918 1421
Вэбсайт: www.soyomboprinting.com
Facebook: SoyomboPrinting



Appendix



The view of an inherited campsite during the Lunar New Year



Women make a praying ritual at their bor shoroo

“БЭЛЧЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ” ТУХАЙ ОНОЛ БА ПРАКТИК

КАМИМУРА АКИРА¹

монголын мал аж ахуй өнгөрсөн XX зууны сүүлийн хагасаас Европ буюу Барууны маягийн хөгжлийн загварыг авч хэрэглэж ирсэн юм. Тухайлбал, социализмын үед малаа нийгэмчилж хөдөө аж ахуйн нэгдлүүдийг байгуулсан. Үүнийг хөгжлийн барууны загварын “социалист хувилбар” (socialist version) гэж үзэж болно. 1990-ээд оны эхээр зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихэд нэгдлүүдийг тараагаад малыг хувьчилсан. Тэр үеэс хойших Монголын мал аж ахуйн салбартай холбогдох хөгжлийн загвар нь үндсэндээ хоёр зүйл болно. Нэг нь “private property model” буюу “хувийн хөрөнгө дээр тулгуурласан загвар”, нөгөө нь “common property model” буюу “нийтийн өмчид тулгуурласан загвар” юм. Монголын эрх зүйн хувьд, эхнийх нь бэлчээр хувьчлах эрх, хоёр дахь нь бэлчээр эзэмших эрхтэй холбоотой. Энэ өгүүлэл, дээрх хоёр загварын үндэслэл болсон онол буюу логик, мөн Монгол нутагт 1999 оноос хойш хэрэгжүүлсэн дээрх загвартай, хөгжлийн төслийн практик жишээнээс авч үзээд уг загварын хэрэгжилт Монголын мал аж ахуйн нийгэм, соёлд цаашид ямар нөлөө үзүүлэхийг тодорхойлох болно.

1. Equilibrial ecosystem vs Non-equilibrial ecosystem

Эхлээд Монголын мал аж ахуйн чанарыг тодорхойлох онолын тухай дурдая. Хур тунадас их бөгөөд хэлбэлзэл нь бага орон нутагт ургах өвсний хэмжээ ч тогтвортой. Өвсний биомасс (одоо байгаа хэмжээ) нь бэлчээрлэх мал, ан амьтны тоогоор тасралтгүй, эргэж буцах маягаар өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл гадны нөлөөгүйгээр шим ертөнцийн доторх өвс, амьтан хоёрын тоо тэнцвэртэй байдаг болно. Үүнийг “тэнцвэртэй экосистем” (Equilibrial ecosystem) гэдэг. Тэнцвэртэй экосистемд байхад тодорхой нэг бэлчээрт тогтвортойгоор малыг тэжээж болох хамгийн их тоо толгойг нь (carrying capacity буюу бэлчээрийн даац) тодорхойлж малын тоог түүнээс хэтрүүлэхгүй байлгах нь чухал болно. Энэ бол барууны уламжлалт бэлчээрийн менежментийн санаа мөн.

Харин хур тунадас бага бөгөөд хэлбэлзэл нь их газарт шим ертөнцийн гаднах хур тунадасны хэмжээгээр ургах ургамлын хэмжээ ихээр өөрчлөгддөг.

Тиймээс өвсний биомас (одоо байгаа хэмжээ), мал, амьтны тоо хоёр нь тэнцвэртэй байдалд байхгүй. Иймэрхүү экосистемийг “тэнцвэргүй экосистем” (Non-equilibrial ecosystem) гэдэг. Тэнцвэргүй экосистемд бэлчээрийн даац гэдэг ойлголт төдий л ач холбогдолгүй бөгөөд хур тунадасны орон зайн хэлбэлзэлийг харгалзан аль өвс сайтай газарт отор хийх нь зохистой зөв арга болно. Ер нь

¹ Япон улсын Токиогийн их сургуулийн Гадаад хэлний сургуулийн судлаач.

аль таатай нөхцөл буюу завшааныг ашиглахыг “opportunistic management (strategy)” гэдэг (Behnke et al. 1993: 11).

Энэ хоёр нь нэг шугамын (spectrum) хоёр туйл бөгөөд бодит тодорхой экосистем бол эдгээрийн дунд оршдог. Мөн энэ хоёрыг ялгавал жилийн дундаж хур тунадасны хэлбэлзэл (CV) нь 30%-аас дээш эсвэл жилийн нийлбэр хур тунадас нь 300-400 мм-ээс доош байхад тэнцвэргүй экосистем гэж үзэж болох юм (Ellis et al. 1993:33,39). Монголын хангайн нутаг буюу ой, хээр талын бүсэд жилийн дундаж хур тунадас 250 мм, хэлбэлзэл (CV) нь 28%, говийн бүсэд 100 мм, хэлбэлзэл нь 50% байдаг болохоор Монгол нутгийн ихэнх нь “тэнцвэргүй экосистем”-д орно гэж хэлж болно (World Bank 2003:3,34).

Энэхүү онол дэлхийн халуун ба хуурай бүсэд оршдог Африкийн орнуудын мал аж ахуйн жишээн дээр боловсруулагдсан учраас Монголын өвөл, хаврын улиралд бол тохирохгүй тал байгаа ч зуд болдог өвөл, хаврын үед л “opportunistic management” буюу отор хийх нь чухал болно гэдгийг үгүйсгэж болохгүй юм. Ялангуяа, сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтийн улмаас зуд зэрэг байгалийн гамшиг болох давтамж нь нэмэгдэж байгааг харгалзан үзвэл отор нь бусдаас хамаагүй үр ашигтай арга байх нь тодорхой байна.

2. “Private Property Model” буюу “Хардингийн “Нийтийн бэлчээрийн эмгэнэлт явдал”

1990-ээд оны эхээр Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж мал хувьчилсан байхад бэлчээр нь төрийн өмч хэвээр үлдсэн юм. Үүнийг шүүмжилсэн Азийн Хөгжлийн Банк (ADB) зэрэг зарим олон улсын тусламжийн байгууллага зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд зайлшгүй хэрэгтэй гээд Монголын засгийн газраас бэлчээрийг хувьчлах хуультай болохыг шаарддаг байсан. Үүний үндэслэл нь Америкийн микробиологич Хардингийн 1968 онд нийтлүүлсэн “Нийтийн бэлчээрийн эмгэнэлт явдал” (Hardin 1968) гэдэг өгүүллийн логик байжээ. Тэрбээр тус өгүүлэлдээ “хувийн малтай үед нийтийн бэлчээр зайлшгүй сүйд болдог” гэсэн санаа дэвшүүлсэн юм.

Хардингийн энэ өгүүллийн логик бол: Малчин нэг толгой малын тоог нэмсэн бол нэмсэн малаас олох ашиг нь бүгд өөрийнх болно. Харин түүний өртөг буюу бэлчээрийн доройтол бол тухайн бэлчээрийг хамт ашиглаж байгаа малчдын тоогоор хуваагдах болно. Ингээд олон хүнээр хуваагдсан өртөг нь олох ашгаас нь хамаагүй бага болох учраас малчин болгон малын тоо нэмэхийг хичээж малын тоо өссөөр байж эцэст нь бэлчээр сүйд болох эмгэнэлт байдалд хүрэх болно. Тэгэхгүйн тулд бэлчээрийг малчдын тоогоор хувааж малчин тус тус өөрийн гэсэн бэлчээртэй байх хэрэгтэй. Тэгсэн бол малаа нэмсэн өртөг буюу бэлчээрийн доройтол нь хуваагдахгүй, бүгд өөрөө хариуцах учраас малчид хамаагүй малаа өсгөхгүй, бэлчээрийг хамгаалж болно гэж товчилж болох юм.

Энд гардаг малчин бол “ухаалаг” (rational) буюу өөрийн ашгийг туйлын их болгохыг (maximize) хичээдэг “орчин үеийн эдийн засгийн хүн” болно. Өөрөөр хэлбэл олон талтай хүний нэг л талыг авч бүтээсэн дүр гэж дүгнэж болох юм.

Энэ логикийг үндэслээд Африкийн орнууд болон өвөр Монголд бэлчээрийг хувьчлах бодлого явуулдаг байсан. Монголын хувьд олон улсын байгууллагын шахалт байсан ч 1992 оны үндсэн хуулийн заалт, иргэдийн эсэргүүцлээс болж бэлчээрийг хувьчлах асуудал удаан үргэлжлэлгүй, нэг их яригдалгүй хууль ч гараагүй өнгөрсөн юм. Хардингийн энэ логик бол зөвхөн бэлчээр биш төрийн өмчийг хувьчлах неолиберализмын гол үндэслэл болж 70-80-аад оноос хойш дэлхийд их нөлөөтэй байсан. Монголд ч гэсэн “шок номлол”-ын (Klein 2007) бодлогуудыг их хүчтэй явуулснаас монголчууд амсах ёсгүй зовлон амссан билээ. Тухайн үеийн иймэрхүү нөхцөл, уур амьсгалыг бодоход Монголын бэлчээр хувьчлагдаагүй үлдсэн нь дэлхийд ховор тохиолдол гэж үзэж болно.

3. “Community Based Natural Resource Management” (CBNRM)

Ингээд 1990-ээд оны сүүл болоход олон улсын хөгжлийн байгууллагын төсөлд “Community Based Natural Resource Management” (CBNRM) нэртэй бэлчээрийн менежмент их газар авчээ. Үүнийг “Common property model” буюу “нийтийн өмчид тулгуурласан загвар” гэж хэлж болно. Малчдын бүлэг (нөхөрлөл) зохион байгуулаад тэдгээр бүлэгт бэлчээрийг эзэмшүүлэх санаатай юм. Олон улсын тусламжийн байгууллагууд үүний дагуу Монголд олон төсөл хэрэгжүүлж, байгуулсан малчдын бүлгийн тоо хоёр мянгыг аль эрт давжээ. Харин үүнээс төсөл дууссаны дараа үлдсэн нь цөөхөн байдаг.

Хардингийн өгүүллийг нийтэлснээс хойш түүний номлосон шиг эмгэнэлт байдалд хурээгүй, урт удаан хугацаагаар тогтвортойгоор ашиглагдаж ирсэн нийтийн өмчийн баялгийн тухай олон жишээ дэлхийн олон газраас ирсээр байна. 2009 онд Нобэлийн эдийн засгийн салбарын шагнал хүртсэн Э.Остором тэр олон жишээг судлаад нийтийн өмчийн баялгийг (Common-Pool Resource (CPR)) урт удаан тогтвортойгоор ашиглах 8 загвар, зарчмыг (design principles) тодорхойлсон юм (Ostrom 1990: 90).

Үүнээс эхнийх нь тодорхой хилийг тогтоох явдал болно. Хил гэдэг нь нийтийн өмч болсон тухайн баялгийн хил (spatial boundary) ба “нийгмийн хил” (social boundary) буюу хэн тухайн баялгийг ашиглах эрхтэй эсэхийг ялгах зааг болно. Малчдын бүлгийн хувьд хэн гишүүн мөн, гишүүн бусыг тодорхой болгох гэсэн үг. Мөн тухайн баялгийн хэмжээ нь бага байх шаардлагатай гэж судлаачид үздэг байна (Agrawal 2002). Монголд CBNRM төсөл хэрэгжүүлж малчдын бүлэг байгуулахад мөн энэ хоёр зарчмыг авч хэрэглэсэн юм. Иймээс багийг дотор нь хэд хувааж байгуулдаг байсан.

Ингээд бэлчээрийг эзэмшүүлэх эрх зүйн үндэслэл болох бэлчээрийн тухай хууль батлагдаагүй байхад бодит байдлаар (de facto) бэлчээрийг эзэмшсэн, олон малчдын бүлэг байгуулагдсан юм.

Одоо 2008 оноос 2013 оны хооронд миний явуулсан хээрийн шинжилгээний үр дүнгээс жишээ авч бэлчээр эзэмшсэн малчдын бүлэгт ямар асуудалтай тулгарч байсан, тулгарч болохыг үзье.

Хүснэгт 1. Монголд хэрэгжсэн гол төслүүд (Website-аас)

Тусламжийн байгууллага	Төслийн нэр (Товчлол)	Хэрэгжсэн хугацаа	Зорилго, Зорилт
The Swiss Agency for Development and Cooperation (SDC)	Green Gold Program (SDC-GG)	2004-2008 (Phase 1) 2009 (Phase 2) 2010-2012 (Phase 3) 2013-2016 (Phase 4)	To strengthen the self-reliance of poor and vulnerable herders to improve their livelihoods through more productive and sustainable use of pastures
United Nations Development Programme (UNDP)-SDC	Sustainable Land Management for Combating Desertification (UNDP-SDC-SLMCD)	2008-2012	To strengthen the enabling environment for sustainable land management by building capacities in appropriate government institutions and user groups
Millennium Challenge Corporation (MCC)	Peri-Urban Rangeland Productivity (MCC-PURP)	2010-2012 (Phase 1) 2012-2014 (Phase 2)	To introduce a system of leasing peri-urban pasture lands to herder groups

*<https://www.eda.admin.ch/countries/mongolia/en/home/internationaloperation/themes/agriculture/green-gold-programme.html> (2015.8.15 үзэв) хасагдсан.

**http://mofa.gov.mn/coordination/index.php?option=com_k2&view=item&id=37:цөлжилтийг-бууруулах-газрын-тогтвортой-менежмент&lang=en (2015.8.15 үзэв) хасагдсан.

***http://mofa.gov.mn/coordination/index.php?option=com_k2&view=item&id=41:монголын-мянганы-сорилтын-сангийн-хот-орчмын-бэлчээрийн-төсөл&lang=en (2015.8.15үзэв) хасагдсан.

4. “The Tragedy of Antcommons” буюу “Баялгийг жижиглэн хувааснаас болсон эмгэнэлт байдал”

Төв аймгийн А суманд бол 2007 оны 4 сараас Швейцарын хөгжлийн агентлагийн (SDC) төсөл (Хүснэгт 1: SDC-GG) хэрэгжсэн. Тус сумын 3 багийн дотор 30-54 өрхөөр бүрэлдсэн 9 малчдын бүлэг (бэлчээр ашиглагчдын хэсэг) байгуулагдсан юм. Төслийн сумын зохицуулагчаас ярилцлага авахад,

“Төсөл эхлээд нэг жилийн дараа хоёр бүлгийг нэгдэн нийлүүлсэн. Учир нь нэг бүлэг нь бэлчээр том, мал багатай байхад нөгөө нь бэлчээр бага, мал ихтэй байсан. Энэ асуудлыг төсөл хэрэгжүүлээд удаагүй байхад ярьж эхлээд нэг жилийн дараа бэлчээр том, мал багатай бүлгийнхнийг ятгаад шийдсэн юм.

Мөн сумын 3 бүлгийн гишүүд өөр нэг бүлгийн дэвсгэрт оршдог орхигдсон тариалангийн талбайд малаа оруулья гэхэд нөгөө бүлгийнхэн тухайн талбайг ашиглаж байгаагүй мөртлөө манай газарт гадны мал оруулахгүй гээд их эсэргүүцсэн. Бас нэлээн удаан ярьж, ятгаад малаа оруулж чадсан” гэж ярих.

Энэ нь баялгийг жижиглэн хувааснаас болж үр ашигтай ашиглах боломжгүй болсон явдал бөгөөд үүнийг Heller гэдэг судлаач 1998 онд Хардингийн эсрэг “anti-commons”-ын эмгэнэлт явдал гэж нэрлэсэн юм.

5. Mobility & Flexibility

Ховд аймгийн В суманд жил болгон 4, 11 сард багийн хурал болж гол голын ахлагчдыг сонгон, ахлагч нь зуслан эсвэл өвөлжөөний бэлчээрт хэзээ гарахыг тогтоож хянадаг. Тус суманд 2008 оноос Швейцарын хөгжлийн агентлагийн төсөл Швейцарын хөгжлийн агентлагийн (SDC) төсөл (Хүснэгт 1: SDC-GG) хэрэгжсэн бөгөөд энэ сумын А багийн хувьд малчид төслийн анхны хуралд дээрх уламжлалаа мөрдөн зуслан, өвөлжөөний гол голынхаа малчдын бүлгийг тус бүр байгуулахаар ярьсан юм. Энэ баг бол малчдын зусдаг А, В, С, D гэсэн ерөхийдөө дөрвөн голтой, өвөлждөг а, b, c, d гэсэн дөрвөн голтой байдаг. Зун, өвлийн улирлын чанартай тус тус дөрвөн малчдын бүлэг байгуулна гэсэн үг.

Гэвч Улаанбаатарт суудаг төслийн ерөнхий зохицуулагч нь үүнийг “замбараагүй” гэж зөвшөөрөлгүй, А-В-а-в, С-D-с-d гэсэн улирлын чанартай биш, жилийн турш гишүүний бүтэц нь өөрчлөгдөхгүй хоёр малчдын бүлэг байгуулахыг шахжээ. Ингэсэн бол зуслан, өвөлжөөний сонголтын тоо нь зуслангийн 4 гол, өвөлжөөний 4 гол, нийт $4 \times 4 = 16$ байснаа $2 \times 2 = 4$ болж цөөрч чөлөөтэй нүүж чадахгүй болно. Өөрөөр хэлбэл малчдын бэлчээрийн сонголт багасч мал аж ахуйн уян хатан байдлыг (flexibility) алдаж чөлөөтэй нүүдэл (mobility) багасах болно. Ийм малчдын бүлэг малчдын хувьд огт хэрэггүй байсан учраас энэ багт бэлчээр эзэмших малчдын бүлэг байгуулагдаагүй байна.


6. Moral Economy vs Political Economy – Ёс зүйн аж ахуйг эвдэх явдал

Төв аймгийн С суманд бол НҮБ-ын Хөгжлийн Төлөвлөгөө (UNDP) болон Швейцарын хөгжлийн агентлаг (SDC) хамтран төсөл (Хүснэгт 1: UNDP-SDC-SLMCD) хэрэгжүүлж байсан. Уг төслийн хүрээнд байгуулагдсан малчдын нэг бүлгийн ахлагчийн ярилцлагаас танилцуулья.

Тухайн малчдын бүлгийг 2009 онд 9 өрх нийлж байгуулсан (Хүснэгт 2). Сумын захиргаатай гэрээ байгуулж хил залгаа Дундговийн малыг оруулахгүй гэсэн нөхцөлтэй баруун захаас зүүн зах хүртэл 15 км, урд захаас хойд зах хүртэл 10 км зайтай хэмжээний бэлчээрийг эзэмшиж авсан юм. Үүнээс өмнө бол зуны улиралд сумын хойд хэсэг рүү нүүдэг байсан. 2009 оноос хойш тэгж нүүхээ больж зун ч гэсэн энд байхаар болсон гэв.

Хүснэгт 2 Тус малчдын бүлгийн өрхий бүтэц

Өрхийн дугаар.	Өрхийн толгойлогчийн нас	Өрхийн гишүүний тоо	Малын тоо	Малчдын бүлгийн ахлагч
1	27	4	250	*
2	49	4	250	
3	58	4	300	
4	53	4	250	
5	30	4	300	
6	26	4	250	
7	26	4	250	
8	35	4	250	
9	50	4	30	
10	40	4	300	
11		3	Зуун-модод суудаг	



Энэ малчдын бүлгийн “эзэмшиж” авсан бэлчээр бол сумынхаа өмнөд захад оршдог, Дундговьд жил дараалан ган болсноос болж урдаас олон мал ирж өвөлжөөний бэлчээрийг идсэн гэх шиг маргаан их үүсдэг газар байв. Монголд иймэрхүү маргааныг уг нь захиргаанаас ёс зүйн үүднээс хандаж зохицуулдаг байжээ. Харин сүүлийн үеийн хувийн эдийн засгийн үйл ажиллагаанд захиргаа нь оролцохгүй гэсэн ‘neoliberalism’ үзэл сурталын шалтгаанаас хандаж захиргааны үүргийг хувийн аж ахуйн нэгж болох малчдын бүлэгт хүлээлгэсэн явдал гэж энэ жишээг үзэж болох юм.

“Moral economy” бол Английн түүхч Thomson утгыг нь боловсруулж James C. Scott-ын 1976 онд нийтэлсэн зохиолоор түгээмэл болсон нэр томъёо юм. Scott уг зохиолдоо зүүн өмнөд Азийн тариачид харилцан туслалцах нормоор (the norm of reciprocity) амьдарч ажиллаж ирсэн бөгөөд төр (patron) нь хүний амь зуух эрхийг (the right to subsistence) баталгаажуулахгүй байдалд хүрсэн тохиолдолд л бослого гаргаж байсан гэж бичсэн. Ийм ёс зүйг шигтгэсэн аж ахуй буюу эдийн засгийг “moral economy”, “ухаалаг” буюу өөрийнхөө ашгийг туйлын их болгохыг хичээдэг “орчин үеийн эдийн засгийн хүн”-ий үйл ажиллагаагаар бүрэлдэн явдаг эдийн засгийг “political economy” гэж хооронд нь ялгадаг.

Дундговьд зун ган болоход хойшоо отор хийж нүүж явахыг төр захиргаа зөвшөөрч зохицуулдаг байсан. Төв аймгийн малчид ч гэсэн байгалийн гамшгаас зугтаж ирсэн ядарсан малчдыг хүлээн авдаг харилцан туслалцах нормтой байсан бөгөөд төр засаг нь ийм ёс зүйг дэмжин хүний амь зуух эрхийг

хамгаалах “safety net” гэж үзээд баталгаажуулж ирсэн билээ. Гэтэл отроор нүүж ирсэн Дундговийн малчдыг гэнэт, бэлчээрийг “дайран довтлогч” гэж үзээд хөөдөг болжээ.

(Мэдээжийн хэрэг өвөлжөөний бэлчээрийг юу ч үгүй идүүлсэн, хашааг эвдэж хаясан зэрэг, зарим нэг малчин байсан.) Отроор С суманд нүүж ирсэн нэг малчин “Хэрвээ бэлчээр эзэмшүүлэх хууль батлагдсан бол иргэний дайн болно” гэж ярьсан юм. Энэ нь зүгээр л Дашбалбарын “Газрын төлөөх тулалдаан эхэллээ” номоос санаа авсан үг байх боловч тэдний хувьд өөрийнх нь амь зуух эрхэнд халдаж болзошгүй ноцтой байдал үүсч байгааг ухамсарлаж байсан хэрэг болно.

Ийм ёс зүйн аж ахуйг (moral economy) хуучин, зайлшгүй “political economy”-гээр солигдох жамтай, дундад зууны үлдэгдэл шиг үздэг нийгэм ухааны судлаач байсан. Гэвч Францын эрдэмтэн Latour (1991) “Бид хэзээ ч (цэвэр) орчин үеийнх байгаагүй” гэж бичсэнээс хойш тэгж үздэггүй болжээ. Америкийн Wall street-д ажилладаг биржийн худалдаачин ч гэсэн гэртээ ирээд хүүхдүүддээ ёс зүй ярьдаг шиг орчин үеийн нийгэм бол хуучин, шинийн холимог (hybrid: Latour бол байгаль/нийгэм, субъект/объект гэх мэт “орчин үе”-ийн дихотомийн тухай бичсэн) чанартай юм.

Нөгөө талаас хүний амь зуух эрх (the human right to subsistence) бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал (Universal Declaration of Human Rights)-д (25-р зүйл) орсон хүний эрхийн доторх гол эрх мөн болно. Энэ жишээнд малчдын бүлэг нь гадны мал ба малчдыг хөөх үүрэгтэй байхад, харин төр засаг, захиргаа нь хүлээх ёстой үүргээ хүлээн авалгүй туйлширвал иргэдийн тээж ирсэн ёс зүйг эвдэх байсан гэж хэлж болох юм.

Дүгнэлт

Хууль батлагдаагүй байхад бодит байдлаар бэлчээр эзэмшсэн дээрх жишээнээс үзэхэд малчдын бүлэгт бэлчээр эзэмшүүлэх заалттай “Бэлчээрийн тухай хууль”-ийн төсөл буюу “Газрын тухай хууль”-ийн өөрчлөлт хэрэгжсэн бол мөн адил асуудал үүсч болзошгүй гэдэг нь тодорхой байна. Монголд малчдын бүлэгт бэлчээр эзэмшүүлэх схем сайн явахгүй байж болох шалтгааныг хоёр хуваан тодорхойлж болно. Нэг нь Остром нарын дэвшүүлсэн загвар, зарчмынх (design principles), нөгөө нь Монголд өвөрмөц нөхцөл болно.

Остром нарын дэвшүүлсэн нийтийн өмчийн баялгийг (CPR) урт удаан тогтвортой ашиглах заавар (design principle) болох тодорхой хил (нийтийн өмч болсон баялаг буюу орон зайн хил ба нийгмийн хил) тогтоох, мөн тухайн баялгийн хэмжээг бага байлгах гэсэн малчдын бүлэг байгуулахад баримтлах хоёр зарчим бол Монголын мал аж ахуйн нөхцөлд тохирохгүй байж магадгүй.

Дээрх А суманд бол баялгийг жижиглэн хувааснаас болж тухайн баялгийг үр ашигтай ашиглаж болохгүйд хүрэх “anticommons”-ийн асуудал үүссэн

байлаа. Уг нь тодорхой хил тогтоогоод гадагшаа мал гаргахгүй, гадны мал оруулахгүй гэсэн зарчмыг төвөөс шаардсан боловч хэрэгжүүлэх боломжгүй гэж үзээд орхисон гэж төслийн сумын зохицуулагч надад ярьсан билээ.

В сумын жишээ нь гишүүний бүтэц нь өөрчлөгдөхгүй, өөрөөр хэлбэл нийгмийн тодорхой хилтэй малчдын бүлэг байгуулсан бол мал аж ахуйн уян хатан байдал (flexibility), чөлөөтэй нүүдэл (mobility) алдаж болзошгүй гэдгийг харуулсан юм.

Мөн С сумын жишээний малчдын бүлэг нийгмийн хилийг чанга хатуу барьж гадны малчдыг хөөх үүрэгтэй байгуулагдсан бөгөөд ийм явдал нь байгалийн гамшгаас зугтаж ирсэн малчдын эрхэнд халдаж, төр засаг баталгаажуулж ирсэн ёс зүйг эвдэхэд хүрч болзошгүй гэж дүгнэлээ.

Остром нарын дэвшүүлсэн дээрх хоёр зарчим Монголын нөхцөлд тохирохгүй гэсэн дүгнэлт нь Монголын малчдын ухамсарт таарч байгаа юм. Ер нь гадаадын тусламжийнхан, Монголын малчид хоёрын хооронд бэлчээрийн тухай ойлголтын хувьд нэлээн зөрүү байдаг. Жишээ нь гадаадын тусламжийнхан бэлчээрийн хилийг тогтоосон бол маргаан үүсэхгүй гэж үздэг байхад Монголын ихэнх малчид хил тогтоосон бол харин ч маргаан их үүсэх болно гэж ярьдаг гэх мэт.

Нөгөө талаас Монголын нөхцлийн хувьд “Бэлчээрийн тухай хууль”-ийг санаачилсан хумүүс Хардингийн логикийг одоо ч гэсэн хэрэглэж байна. Тухайлбал, 2010 оны “Бэлчээрийн тухай хуулийн төслийн танилцуулга”-д “... бэлчээрийг нийтээр дундаа үнэгүй ашиглах уламжлалт аргаар зохицуулах нь өнөөгийн шаардлагад төдийлөн нийцэхгүй байна”, мөн “Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-д, “... бэлчээрийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүнд хөрөнгө оруулах” гэх мэт. “Бэлчээрийг эдийн засгийн эргэлтэд оруулах” юм бол эхлээд бэлчээрийг хувийн өмч болгох хэрэгтэй. Тиймээс бэлчээрийн тухай хууль зайлшгүй бэлчээрийг өмчлүүлэх хуультай адилхан, ялгаагүй үйлдэлтэй хууль болно.

Ном зүй

1. Agrawal, A. Common Resources and Institutional Sustainability. In Ostrom, E., Dietz, T., Dolsak, N., Stern, Paul C., Stonich, S., and Weber, Elke U. (eds.) 2002, *The Drama of Commons*, National Academy Press, pp. 41-85. 2002.
2. Behnke, R.H., Scoones, I. Rethinking Range Ecology: Implications for Rangeland Management in Africa. In Behnke et al.(1993), pp.1-30. 1993.
3. Behnke, R.H., Scoones, I. and Kerven, C.(eds) Range Ecology at Disequilibrium: New Models of Natural Variability and Pastoral Adaption in African Savanas, London: ODI. 1993.
4. Ellis J.E., Coughenour, M. B. and Swift, D. M. Climate Variability, Ecosystem Stability, and the Implications for Range and Livestock Dvelopment. In Behnke et al. (1993), pp.31-41. 1993.
5. Hardin, G. The Tragedy of the Commons. *Science*, 16 2: 1243-1248. 1968.
6. Heller, M.A. The Tragedy of the Anticommons: Property in the Transition from Marx to Markets. *Harvard Law Review*, 111(3):621-688. 1998.
7. Kamimura, A. Pastoral mobility and pastureland possession in Mongolia. In: N. Yamamura, N. Fujita, and A. Maekawa (eds.) *Environmental Issues in Mongolian Ecosystem Network under Climate and Social Changes*. Springer. pp. 189-205. 2012.
8. Klein, Naomi The Shock Doctrine: The Rise of Disaster Capitalism. Metropolitan Books. (Клайн, Наоми (2018) Шок номлол: Гамшгийн капитализмын үүсэл, Монсудар. О.Гомбожав, С.Ганбат очуулав.) 2007.
9. Latour, Bruno Nous n'avons jamais été modernes : Essai d'anthropologie symétrique, La Découverte. (Ангил хэлний орчуулга (1993) *We have never been modern*, Harvard University Press. 1991.
10. Ostrom, E. Governing the Commons: the Evolution of Institutions for Collective Action. Cambridge University Press, Cambridge. 1990.
11. Scott, James C. The Moral Economy of the Peasant: Rebellion and Subsistence in Southeast Asia. 1976.
12. Taylor, J.L. Negotiating the Grassland: The Policy of Pasture Enclosures and Contested Resource Use in Inner Mongolia. *Human Organization*, 65- 4, pp.374-386. 2006.
13. World Bank. Land Resources and Their Management: Mongolia environment monitor 2003. World Bank. 2003.
14. United Nations. Universal Declaration of Human Rights (Хүний эрхийн түгээмэл тунхаглал https://unicode.org/udhr/d/udhr_khk.html) 1948.